

ХОГ ХАЯГДАЛ БА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ ТӨСӨЛ



Бутан, Монгол болон Балба улсад хог хаягдлаас ялгарах хүлэмжийн хий, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх богино наст бохирдуулагч бодисыг хаягдалгүй эдийн засгийн үзэл баримтлалд суурилан бууруулахад оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх

Монгол улсад сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд хотжилт асар хурдацтай явагдаж байна. Өнөөдрийн байдлаар Монгол улсын нийт 3 сая хүн амын 50 орчим хувь нь нийслэл хот Улаанбаатарт амьдарч байгаа бөгөөд хотын газар нутгийн тал хувьд нь буюу гэр хороололд нийт оршин суугчдын 60 орчим хувь оршин сууж байна. Хот төлөвлөлт сайн хийгдээгүй, шилжилт хөдөлгөөн их, төсөв санхүүжилт хүрэлцдэггүй, мэдээ, мэдээлэл дутмаг, хариуцлага тооцоох тогтолцоо сул, авлига, хээл хахууль зэрэг олон шалтгааны улмаас гэр хорооллын иргэдэд хүрч буй үйлчилгээний, тэр дундаа хог хаягдал ачилт, тээвэрлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмж тааруу байсаар байна. Олон нийтийн газар ил задгай хог хаягдал элбэг тохиолдох тул иргэд, оршин суугчид энэ талаар гомдол гаргах нь олонтоо. Мөн хогийг ил задгай шатааснаас хүлэмжийн хий болон уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх богино наст бохирдуулагч бодис ихээр ялгарах бөгөөд энэ нь иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөс гадна ус, агаар, хөрсний бохирдлыг нэмэгдүүлж, байгаль орчны доройтолд хүргэж байна.

Хог хаягдал нь зөвхөн байгаль орчин, нийгмийн асуудал болоод зогсохгүй эдийн засгийн хувьд үр ашиггүй, алдагдалтай байдлыг бий болгож байна.

Монгол улс хогийг баялаг болгож, эдийн засгийн эргэлтэд оруулснаар хог хаягдлыг эрчим хүч болон бусад хэрэгцээт материалын эх үүсвэр болгон ашиглах бүрэн боломжтой юм. Өнөөгийн байдлаар Монгол улс уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулааралтай тэмцэхэд үр өгөөжтэй байж болох нүүрстөрөгч багатай технологийг судлан, хог хаягдлын салбарт хараахан нэвтрүүлж чадаагүй байна.

Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд хийгдсэн бодлого, эрх зүйн орчны шинэчлэлийн үр дүнд Монгол улсад хог хаягдлын менежментийг сайжруулах боломж бүрдээд байна. Монгол улсын Их Хурал 2014 онд Монгол улсын Ногоон хөгжлийн бодлогыг баталсан бөгөөд 2017 онд Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталсан. Мөн НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн туслалцаа, дэмжлэгтэйгээр хог хаягдлын менежментийг сайжруулах Үндэсний болон Улаанбаатар хотын стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг 2017 онд боловсруулж дуусгасан билээ.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Монгол улсад хог хаягдлаас ялгарах хүлэмжийн хий, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх богино наст бохирдуулагч бодисыг бууруулах боломж бололцоо их байна.

Тиймээс энэхүү төслийн хүрээнд байгаль орчинд ээлтэй зохистой технологи сонгох, нэвтрүүлэх, ашиглахад чиглэсэн эрх зүй, санхүү болон технологийн орчныг бүрдүүлж, бий болгоход төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад дэмжлэг үзүүлэн ажиллах юм. Төслийн хүрээнд холбогдох бодлогын баримт бичгийн шинэчлэл хийх, байгаль орчинд ээлтэй, зохистой технологийг олж тодорхойлон нэвтрүүлэхэд техникийн туслалцаа үзүүлж, институтын чадавхыг бэхжүүлэх бөгөөд ингэснээр хог хаягдлаас ялгарах хүлэмжийн хий, богино наст бохирдуулагч бодисын хэмжээг бууруулж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Монгол улсын оруулах зорилтот хувь нэмрийг (INDC)-ийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

Төслийн үр дүн, сургамж болон кейс судалгаа бүхий тайланг бэлтгэн боловсруулж, оролцогч талуудтай нээлттэй хуваалцах бөгөөд ингэснээр ижил төрлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхийг хөхүүлэн дэмжих болно.

ҮР ДҮН:

Төслийн оролцогч талууд сайжирсан эрх зүйн орчны хүрээнд үйл ажиллагаа явуулж, хог хаягдлын менежментийг сайжруулах байгаль орчинд ээлтэй технологийг

нэвтрүүлэх, ашиглах нөхцөлийг бүрдүүлснээр уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Монгол улсын оруулах зорилтот хувь нэмэр (INDC)-ийг нэмэгдүүлнэ.

ГАРЦ 1:

Хүлэмжийн хий болон уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх богино наст бохирдуулагч бодисын хэмжээг бууруулахад чиглэсэн үндэсний болон хотын түвшний хог хаягдлын цогц стратегийг боловсруулсан байна.

ГАРЦ 2:

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн “Технологийн тогтвортой байдлын үнэлгээнд” суурилан хог хаягдлын салбарт байгаль орчинд ээлтэй технологийг тодорхойлсон байна.

ГАРЦ 3:

Хог хаягдлаас ялгарах хүлэмжийн хий болон богино наст бохирдуулагч бодисын хэмжээг бууруулахад чиглэсэн байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэхэд ногоон санхүүжилтийн боломжийг олж тодорхойлон, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах чадавх сайжирсан байна.

ГАРЦ 4:

Төрийн албан хаагчид, бизнес эрхлэгчид болон олон нийт хог хаягдлаас ялгарах хүлэмжийн хий, бусад бохирдуулагч бодисын хэмжээг бууруулахын ач холбогдлын талаар мэдлэг, мэдээлэлтэй болсон байна. Тэргүүн туршлага, холбогдох мэдлэг, мэдээллийг олон нийтэд түгээсэн байна.

Азийн сан нь ашигийн бус, төрийн бус, олон улсын хөгжлийн байгууллага бөгөөд АНУ-ын Сан Франциско хотод төвтэй, Азийн 18 орон болон АНУ-ын Вашингтон Ди Си хотод салбаруудтай. Төр, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагуудтай хамтран засаглал, эдийн засгийн хөгжил, эмэгтэйчүүдийг чадавхжуулах, байгаль орчныг хамгаалах, бүс нутгийн хамтын ажиллагааг дэмжих зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Төв байр



465 Калифорни гудамж, 9-р давхар, Сан Франциско хот, СА 94104 АНУ
Утас (415) 982-4640
Факс: (415) 392-8863

Монгол дахь суурин төлөөлөгчийн газар

Ориент Плаза, 3-р давхар
Г.Чагдаржавын гудамж
Төв шуудан, ш/х 1003
Улаанбаатар хот, 14210
Монгол улс
Утас: 976-11-330524
Факс: 976-11-311497
www.asiafoundation.org

ТӨСӨЛ ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА: 2017 оны 7 дугаар сар- 2021 оны 7 дугаар сар

ТӨСЛИЙН САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА: Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Байгаль орчин, байгаль хамгаалал, барилга байгууламж, цөмийн зэвсгийн аюулгүй байдлын асуудлыг хариуцсан яам, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Олон улсын хүрээлэн буй орчны технологийн төв (UNEP-IETC)

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА: НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Олон улсын хүрээлэн буй орчны технологийн төв (UNEP-IETC)

ТӨСЛИЙН ГОЛ ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД: Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба

ТӨСЛИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД: Чадавх бэхжүүлэх, Бодлогын дэмжлэг, Технологи дамжуулах, турших, Санхүүгийн арга хэрэгслээр дамжуулан хөрөнгө оруулалтыг дэмжих